

**М.Батбаатар***МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш*

## МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ СУДЛАХ АРГА ЗҮЙН АСУУДЛУУД; ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХЭМЖИХ БОЛОМЖИЙН ТУХАЙД

**Abstract:** *This article explores the methodological issues of quality of life (QOL) study. In the paper, the author studied alternative quality of life concepts and considered some measurable entities of QOL.*

**Key words:** *Quality of life (QOL), happiness, living standard, life satisfaction*

### **Нэр томъёоны тухайд**

Дэлхий нийтээр эдүгээг хүртэлх амьдралынхаа сургамжид үндэслэн цаашид хүн төрөлхтөн хэрхэн амьдрах тухай шинэ үзэл баримтлал, зарчмууд бүхий хүний амьдралд таатай, эерэг нөхцлийг тодорхойлох харилцан адилгүй хөгжлийн загваруудыг дэвшүүлэх оролдлогууд хийсээр байна. Эрдэмтэн, судлаачид өнөөгийн улс орнуудыг суурьшил(нүүдлийн ба хотожсон), улс төрийн дэглэм(авторитари, тоталитар, ардчилсан), улс төр, эдийн засгийн тогтолцоо(социалист ба капиталист, нээлтэй ба хаалттай)-ны хувьд ангилахын зэрэгцээ тухайн нийгмийн хөгжил, дэвшлийн хүрсэн түвшинг сайн сайхан байдал, амьдралын чанарын индексээр харьцуулан судлах явдал нийтлэг боллоо.

Өнөөгийн нийгмийн ахиц дэвшил, хүний хөгжил, сайн сайхан байдал, ядуурал, амьжиргааны түвшинг аль алиныг нь шүүмжлэлтэйгээр авч үзэж, тайлбарлаж буй үзэл баримтлал бол “амьдралын чанарын тухай” сургаал юм. Түүхэн байдлаар авч үзэхүл улс орнууд социалист болон капиталист хоёр системд хуваагдаж, нийгмийн хөгжлийн хүрсэн түвшин болон хүмүүсийн амьдралын нөхцлийг хэлэлцэх үест энэхүү үзэл баримтлал зүй ёсоор дэвшигдэн гарч иржээ.

“Амьдралын чанар” хэмээх нэр томъёог анх 1964 онд АНУ-ын ерөнхийлөгч Л.Жонсон нийгмийн зорилгыг тайлбарлахдаа хэрэглэсэн талаар социологич С.Макколл[McCall:229] тэмдэглэжээ. Энэ үеэс тухайн ойлголт шинжлэх ухааны эргэлтэнд орж, улмаар үзэл баримтлал болох хүртлээ философи, эдийн засаг, сэтгэл судлал, эрүүл мэнд болон социологийн хүрээнд судлагдсан байна.

“Амьдралын чанар” бол нэг талаар хүний амьдралын үндсэн нөхцөл болох эрүүл чийрэг байдал, өмчлөл, амьжиргааны байдал, нөгөө талаар хүний үндсэн хэрэгцээнүүд болох аюулгүй байх, харилцаа холбоотой байх, халдашгүй байх зэрэг олон тооны хүчин зүйлсээр тодорхойлогддог[Scott&Marshall:539] өргөн хүрээтэй ойлголт юм. Ийм ч учраас социологич Тодоров “хүний оршин ахуй, оюун санаа, соёл, гоо зүйн хэрэгцээг илэрхийлэхийн зэрэгцээ хүний зан үйлийн хэм хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн болон бусад институцийн үйлчилгээний чанар зэрэг үзүүлэлтүүдийн илэрхийлэл болохын хувьд амьдралын чанар хэмээх нэр томъёо бол социологийн ухагдахуун”[Тодоров:68] болохыг тэмдэглэжээ.

Өрнөдийн судлаачдын хувьд амьдралын чанарыг судлах асуудал 1970-аад оноос эрчимжсэн бөгөөд энэхүү ойлголтын агуулга болон хүрээг тогтоох тал дээр олон янзын санал, хувилбар гаргасаар байна[Попов:14]. Хүний амьдралын чанарын талаар харилцан адилгүй үзэл, тайлбарлал бийг багцлан үзвэл хүний амьдралыг субьектив сэтгэл ханамжаар төлөөлүүлэн үзэх, нөгөөтэйгүүр хүний амьдрах орчинг бүрдүүлж буй объектив нөхцлүүд болон хүрээлэн буй орчинд тулгуурлан авч үзэх үндсэн чиглэлүүд бий.

Дурдсан чиглэлд тулгуурлан хүний амьдралын чанарыг дараах хандлага, түвшинд хуваан судалж болох юм. Үүнд:

1. Сэтгэл ханамжид тулгуурласан хандлага
2. Хэрэгцээнд тулгуурласан хандлага
3. Асуудалд тулгуурласан хандлага



*Нэгд.* Амьдралын чанар хүний сэтгэл ханамж, үнэлгээгээр тодорхойлогдоно. Үүнийг амьдралын чанарыг тайлбарлах субъектив хандлага хэмээн үзэж болохын сацуу энэ түвшинд хүн өөрийн амьдралын чанарыг өөрөө тайлбарлан илэрхийлэгч байна. Хүний сэтгэл ханамж ихэнх тохиолдолд хэрэгцээ хэрхэн хангагдсанаас үүдэлтэй болохыг энэ чиглэлийн судалгаанууд баталдаг.

*Хоёрт.* Амьдралын чанар бол хүний амьдарч буй нөхцлүүдээр тодорхойлогдоно. Хүний амьдарч буй сууц, эзэмшиж буй өмч хөрөнгө, олж буй орлого зэрэг материаллаг зүйлс төдийгүй нэр төр, бусадтай харилцаатай байх гм хэрэгцээт зүйлсийг үүнд хамааруулна. Энэ түвшинд хүний амьдралын чанарыг хувь хүн өөрөө үнэлээд зогсохгүй бүлгийн түвшинд дүгнэж, цэгнэх бөгөөд объектив шинжтэй.

*Гуравт.* Амьдралын чанар бол хүний амьдарч буй байгалийн болоод нийгмийн орчны хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Эдгээр нь байгалийн тэнцвэрт, бохирдолгүй(агаар, ус, хөрс гм) байдал болоод нийгмийн сайн сайхан байдлаар(аюул түгшүүр, эрсдэлгүй байдал гм) тус тус илэрхийлэгдэнэ. Олон нийт, төр засгийн бодлогын түвшинд дурдсан асуудлыг авч үздэг. Амьдралын чанар хэмээх нэр томъёог ойлголтын хувьд тодорхойлж, агуулгыг эцэслэн тогтох нь эл чиглэлийн судалгаанд арга зүйн ач холбогдолтой юм.

**Ойлголтыг тодорхойлох нь**

“Амьдралын чанар” хэмээх нэр томъёо хувь хүний болоод нийгмийн сайн сайхан байдлыг илэрхийлэх шинжлэх ухааны ойлголтоос төрийн бодлогын хэмжээнд тавигдах үзэл баримтлал болтлоо хэд хэдэн чиглэлээр авч үзэгдэж байжээ.

Эхний чиглэл бол амьдралын чанарыг хүний объектив амьдралын нөхцөлтэй холбон үздэг. Амьдралын чанарыг тодорхойлоход амьдралын нөхцлийг илтгэн харуулах өмч, эд хөрөнгө, орон байр, аюулгүй байдал шийдвэрлэх үүрэгтэй болохыг барууны зарим судлаачид тэмдэглэж[Costanza R et al: 267–276] байв.

**А) Хүний амьдралын чанарыг амьдралын нөхцөл тодорхойлно.**



Энэ тохиолдолд “амьдралын чанар” хэмээх ойлголтыг хүний амьдралын нөхцөл гэсэн ойлголтоор төлөөлүүлэн үздэг. Социалист нийгэмд хүний амьдралын чанар, сайн сайхан байдлыг бий болгохдоо үнэлэмж хандлагаас илүүтэй, амьдралын нөхцлийг сайжруулахыг гол болгож байсныг[Жишээ нь, социализмын материал техникийн суурийг байгуулах М.Б] ном зохиолд тэмдэглэсэн[Дашжамц:52] нь бий. Нөгөөтэйгүүр 1970-аад оноос АНУ болон барууны хэд хэдэн орнуудад хийгдсэн амьдралын чанарыг хэмжих суурь судалгаанаас “амьдралын чанар бол баялгийг эзэмших, хэрэгцээгээ хангах, аз жаргалтай байх нөхцлийг хангах явдал” гэж үздэг болох нь харагдсан[Тодоров: 14-15] байна. Гэсэн хэдий ч, амьдралын чанар хэмээх ойлголтыг дан ганц хүний материаллаг хэрэгцээ болон түүний хангамжаар тодорхойлох нь учир дутагдалтай юм. Учир нь материаллаг хангамж ба хуримтлал бол сэтгэл ханамжийн хамгийн доод үнэлгээний илэрхийлэл мөн [Попов:24] гэдэгтэй ихэнх судлаачид санал нэгддэг. Хүний амьдралын чанарыг амьдралын нөхцөл, хэрэгцээ хангагдсан эсэхээс үл хамаарч сэтгэл ханамжийг гол болгон тодорхойлоход дараагийн чиглэл хамаардаг.

**Б) Амьдралын чанар хэмээх ойлголтыг хүний сэтгэл ханамжийн байдлаар тодорхойлно.**




Хөгжингүй нийгэмд хувь хүний сэтгэл ханамжийг ихээхэн чухалд тооцож, үүнд тулгуурласан амьдралын нөхцөл, орчинг бүрдүүлэн бий болгоход анхаарч байна. Өнөөгийн

европын орнуудад нийгмийн хөгжлийн хүрсэн түвшинг хүний сэтгэл ханамж, аз жаргалын түвшингээр илэрхийлэх явдал хааяагүй тааралддаг. Хэдийгээр сэтгэл ханамж бол хүний амьдралын чанарыг тодорхойлох нэгэн хүчин зүйл мөн боловч ихээхэн субъектив шинжтэй учир нэг төрөл болгон хэмжихэд төвөгтэй болохыг эл чиглэлээр хийсэн зарим судалгаа[Campbell and others: 24]-нд цохон тэмдэглэсэн нь бий.

Дараагийн чиглэл бол амьдралын чанарыг тайлбарлахдаа амьдралын нөхцөл, сэтгэл ханамж зэрэг ойлголтуудыг “хосмог” түвшин болгон авч үздэг. Тухайлбал эл хандлагыг баримтлагчид хүний “амьдралын чанар” бол амьдралын нөхцөл болоод түүнд хандах сэтгэл ханамжийн үнэлгээ, хүний үнэлэмж, хандлагын нийлбэр цогц бөгөөд эдгээрийн үр дүнд бий болдог[McCall:147] хэмээн нотолдог.

**В) Амьдралын чанар бол хүний амьдралын нөхцөл болоод сэтгэл ханамжийн түвшинг илэрхийлэх үзүүлэлтүүд(чухал ба чухал бус) болон хүний үнэлэмжээр тодорхойлогдоно.**



Барууны олонх судлаачид “амьдралын чанар” бол хүний хэрэгцээгээ хангах түвшинтэй холбоотой, иймд хүмүүс хувийн амьдралаа бүхэлд нь буюу зарим хэсгийг хэрхэн үнэлж байгаагаар тодорхойлогдоно гэж үздэг. Түүнчлэн амьдралын чанарыг амьдралын боломж(аз тохиолдол) хийгээд үр дүн болох орлого, эрүүл мэнд, нийгмийн харилцаа, байр суурь, эрх чөлөө, халдашгүй байдал зэрэгтэй холбон тайлбарлах явдал[Veenhoven:1] түгээмэл болж байна. Амьдралын чанар хэмээх ойлголт хүний сэтгэл ханамж, амьдралын нөхцлийг илэрхийлээд зогсохгүй хүний хэрэгцээ, амьдралын хэв маягт үзүүлэх экологийн нөлөөлөл, хүн ам зүйн асуудлууд, ардчилал, эрх чөлөө зэрэг орчин үеийн глобал шинжтэй асуудлуудыг хамрах болсноор агуулгын хувьд өргөжин нийгмийн хөгжлийн тухай үзэл баримтлал болсон байна. Эдүгээ “амьдралын чанар” хэмээх нэр томъёо хувь хүний болоод нийгмийн сайн сайхан байдлыг үнэлэхэд өргөнөөр хэрэглэгдэж буйн зэрэгцээ олон нийтийн хөтөлбөр, төрийн бодлого, хөгжлийн санаачлагын талаарх өрсөлдөхүйц үзлүүдийг өөртөө багтаасан[Scott&Marshall:539] үзэл баримтлал болж нэгэнт чаджээ.

**Амьдралын чанарыг хэмжих боломж, аргазүйн асуудлууд**

Амьдралын чанарыг хэмжих бололцооны талаар судлаачид хоёрдмол байр суурьтай байх бөгөөд нэг хэсэг нь амьдралын чанар бол хүний уг чанартай холбоотой, субъектив зүйл тул нэгдсэн нийгмийн индикаторт оруулан хэмжих бололцоогүй зүйл[Bunge:65] гэж үзсэн байхад нөгөө хэсэг нь амьдралын чанарыг хэмжих бололцоотой төдийгүй, энэ нь зайлшгүй зүйл[Veenhoven:1-2] гэжээ. Амьдралын чанар хэмээх ойлголт нь нийгмийн нарийн төвөгтэй үзэгдлийг хэмжих зорилго бүхий нийгмийн индикатор буюу үзүүлэлтүүдийг агуулж байдаг. Хүний амьдралд хүнс тэжээл, хувцас хунар, амьжиргаанд хэрэгтэй материаллаг зүйлс зайлшгүй хэрэгтэй бөгөөд эдгээрийг бүхэлд нь амьжиргааны түвшин хэмээх ойлголтоор илэрхийлдэг. Амьжиргааны түвшин хэмээх ойлголт нь зарим талаар амьдралын чанарын тоон илэрхийлэл болдог. Энэ талаар философич, түүхч А.Тойнби “амьжиргааны түвшин бол арга хэрэгсэл, харин амьдралын чанар бол хүний амьдралын зорилго мөн”[Toynbee:69] хэмээн оночтой тэмдэглэжээ. Хөгжингүй улс орнуудад амьдралын чанарын талаар олон тооны нийгмийн шалгуур үзүүлэлтүүд гаргасан байдаг. Тухайлбал, НҮБ-аас 12 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон [UNO:1961] нь: эрүүлийг хамгаалах байдал, оршин ахуйн нөхцөл хүмүүжил, хөдөлмөрийн нөхцөл, хүн амын ажил эрхлэлтийн байдал, хэрэгцээ ба нөөц тээвэр ба харилцаа холбоо, амьжиргааны байдал, барилгажилт, хувцас хунар, амралт зугаа цэнгэл, нийгмийн итгэлцэл, хувийн эрх чөлөө гм-ийг хамарсан байна.

Харин НҮБ-ын европын эдийн засаг хариуцсан хороо эдгээр нийгмийн индикаторуудыг системчлэн 8 бүлэгт хуваан үзсэн нь бий. Үүнд: эрүүл мэнд, ажлын байрны чанар, бүтээгдэхүүн худалдан авалт ба үйлчилгээ, чөлөөт цагаа өнгөрөөх боломж бололцоо, нийгмийн итгэлцлийн мэдрэмж, бие хүний хөгжих боломж, хүрээлэн буй физик орчны чанар, нийгмийн амьдралаас суралцах боломж зэргийг оруулж үзсэн. Барууны томоохон хэвлэл болох “Эдийн засагч”

сэтгүүлд амьдралын чанарыг тодорхойлох 15 “нийгмийн индикатор”-ыг тодорхойлсон. Эдгээрийг дурдвал, нэг эмчид ноогдох хүн амын тоо, амиа хорлолтын хувь хэмжээ, хүүхдийн эндэгдэл, дээд боловсрол эзэмшиж буй оюутны тоо, хүн амд ноогдох телевизор ба телефон утасны тоо, авто ослоор нас барагсдын тоо, усанд орох боломж бүхий хүн амын тоо, хүн амд ноогдох хүний амь егүүтгэсэн тоо хэмжээ, хүн амын дундах эрт гэрлэлт ба салалтын тоо, эдийн засгийн хөгжил гм-ийг оруулжээ. Эдгээрийг нэгтгэн үзэхэд нийгмийн хөгжил, хүн амын амьдралын хэв маягаас хамааран амьдралын чанарыг хэмжих үзүүлэлтүүд харицан адилгүй байж болох ч, олон улсын түвшинд харьцуулах үзүүлэлтүүдтэй нэг төрөл, харьцуулж болохуйц жишиг үзүүлэлт байх нь зүйтэй юм.

Иймд хүний амьдралын чанарыг судлахад олон талт хандлага, арга зүй, аргачлал шаардагдана. Монгол хүний амьдралын чанарыг хэмжин, гарч буй үндсэн өөрчлөлтийг судлахад нэн тэргүүнд дараах зүйлсийг харгалзан үзэх нь арга зүйн хувьд ач холбогдолтой юм. Үүнд:

1. Монгол хүний нийгэм, соёлын байдал амьдралын чанарын судалгаанд онцгой нөлөөтэй. Социалист тогтолцооноос зах зээлийн, нээлттэй, ардчилсан тогтолцоонд шилжих үйл явц дахь хүмүүсийн амьдралын хэв маяг, хүн амын өмнө тулгамдаж буй нийтлэг асуудлууд хот хөдөөгийн суурьшлын онцлогийг харгалзан үзэх нь чухал. Түүнчлэн нийгмийн томоохон өөрчлөлтийг(мал хувьчлал, өмч хувьчлал, орон сууц хувьчлал, газар хувьчлал гм М.Б) бүртгэн, амьдралын чанарын судалгаанд ашиглах нь ихээхэн ач холбогдолтой.

2. Монгол хүний оршин ахуйн нөхцөл, орчин амьдралын чанарыг судлахад ихээхэн нөлөөтэй. Монголын өргөн уудам нутаг, цөөн тооны хүн ам, засаг захиргаа, нийгмийн үйлчилгээ, эрхэлж буй аж ахуй болоод сууцны нөхцөл зэргийг харгалзах нь нэн чухал болно.

3. Монгол хүний өдөр тутмын харилцаа, амьдралын хэв маяг, бүлгийн харилцаагаас амьдралын чанарыг үнэлэх үнэлэмж гойд хамаарна. Иймд Монгол хүний өдөр тутмын харилцаанд гарч буй онцлог, сонирхол, хэрэгцээ, хэрэглээ, үйл ажиллагааны хэв маягийг микро түвшний үүднээс, бие хүн судлалын хандлагаар судлах нь илүү үр дүнтэй.

4. Монгол хүний амьдралын чанарыг шинжлэхэд олон улсын аргачлал, индексүүд чухал нөлөөтэй. Амьдралын чанарын өөрчлөлтийг гаргахын тулд хэмжих боломж бүхий шалгуур үзүүлэлтүүдийг гаргахын зэрэгцээ эдгээр үзүүлэлтүүдэд тулгуурлан социализмын дараах үеийн Монгол хүний амьдралын чанарт гарч буй өөрчлөлтүүдийг бусад улс орнуудтай харьцуулан шинжлэх шаардлагатай.

5. Монгол хүний хөгжлийн индекс, амьжиргааны түвшин, ядуурлын талаарх тоо баримтуудыг харгалзах шаардлагатай. Ингэхдээ хот, суурин, хөдөөгийн хүн амын онцлог хэрэгцээ, асуудлыг харьцуулан амьдралын чанарын зарим ялгааг гаргах нь чухал юм.

6. Монгол хүний унаган төрх(менталитет)-өөс амьдралын чанарын талаарх үнэлгээ тодорхой хэмжээнд хамаарна. Юуг сайн ба муу, сайхан ба муухай, чухал ба чухал бус гэж үздэг тогтсон хандлага болоод төсөөлөл, санал бодол, зан үйл, үнэлэмжийн тогтолцоог Монгол хүний амьдралын чанарыг судлахад харгалзвал зохино.

### Ном зүй

1. McCall S (1975) Quality of life. Social indicators research. Vol.2 N2
2. Scott J, Marshall G (2005) Oxford dictionary of sociology. Oxford University press
3. Тодоров Ангел Ст (1980) Качество жизни. Критический анализ буржуазных концепций., М; Издательство “Прогресс”
4. Попов С И (1977) Проблема качество жизни в современной идеологической борьбе. М.Наука
5. Дашжамц,Д Дашпүрэв,Д Чулуунжав,Д (1982) БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжиж буй асуудал. ШУА-ийн хэвлэх үйлдвэр
6. Costanza R. et al. (2007). Quality of Life: An Approach Integrating Opportunities, Human Needs, and Subjective Well-Being. Ecol. Econ
7. Campbell A. Converse P.E and Rodgers W (1975) “The quality of American life”; Perceptions, Evaluations and Satisfactions. Russel, Sage Foundation.
8. Bunge M (1975) What is a quality of life indicator? “Social Indicators research”. Vol. 2, N1
9. Veenhoven R (2000) The four qualities of life; ordering concepts and measures of the good life. Journal of Happiness studies, Vol.1
10. Toynbee A J(1962) America and the World revolution. London, NY, Toronto
11. UNO. International definition and measurement of standards and levels of living, NY, 1961
12. Forrester W. World Dynamics, Cambridge, 1971